

Цөхрөлтгүй сэргэг бай

Арван Хоёр Төлөөлөгчийн Чуулгын

Ахлагч Давид А.Беднар

Сүнслэг байдлын хувьд эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоо нь . . . хүүхдүүдийнхээ талаар анхаарал сэргэг байж, тэднийг ялган танихад Сион дахь эцэг эхчүүдэд тусалж чадна.

Саяхан би, аянгын борооны дуслууд машины цонх цохилон урсах зуур машинаа барин явж байлаа. Замын хажууд цахилгаан самбар дээр зориуд сэрэмжлүүлэг болгож, “Тогтсон ус өмнө чинь байна” гэсэн үгс ассан байлаа. Миний явж байсан зам аюулгүй мэт харагдаж байв. Гэхдээ энэхүү чухал мэдээлэл намайг харж чадахгүй байгаа, тохиолдож болно гэж мэдээгүй байсан аюулд бэлтгэх боломжийг олгосон юм. Би очих газраа чиглэн явах зуур, хурдаа сааруулж аюулын шинж тэмдгийг анхааралтай ажиглаж байлаа.

Бидний амьдралын олон тал дээр урьдаас сэрэмжлүүлэх дохионууд илэрхий харагддаг. Жишээ нь, халуурч байвал энэ нь ямар нэг өвчний шинж дохио байж болно. Орон нутгийн болон улс орны эдийн засгийн байдлын ирээдүйн байдлыг харуулах санхүүгийн болон хөдөлмөрийн зах зээлийн олон үзүүлэлт байдаг.

Дэлхийн ямар бүст амьдарч байгаагаас шалтгаалан, бид цасны нуруулт, далайн шуурга, цунами, хар салхи, үер эсвэл өвлийн цасан шуурганы талаар сэрэмжлүүлэг хүлээн авдаг.

Түүнчлэн бид нар амьдралд маань хамгаалалт мөн удирдамжийн эх булаг болох сүнслэг байдлын сэрэмжлүүлгийг урьдаас хүлээн авахаар адислагдсан билээ. Ноа хараахан харагдаагүй байсан зүйлсийн талаар сэрэмжлүүлэн мөн тэрээр “гэр бүлийнхээ авралын төлөө хөвөгч авдар (Еврей 11:7) бэлтгэснийг санаж байгаа биз дээ.

Лихайн наманчлахыг тунхаглаж байсан хүмүүс амийг нь бүрэлгэхээр завдаж байсан учраас¹ Иерусалимаас, гэр бүлээ аван гарахыг Лихайд сэрэмжлүүлэн сануулсан ажээ (1 Нифай 2:1-2-үз).

¹

Аврагч өрөө тэнгэр элчийн сэрэмжлүүлгээр аврагдаж байлаа. “Эзэний тэнгэр элч Иосефийн зүүдэнд үзэгдэж, Бос, Хүүхдийг эхтэй нь хамт авч Египет уруу зугт. Намайг чамд хэл дуулгатал тэндээ бай. Учир нь Херод Хүүхдийг хөнөөхөөр эрж хайх гэж байна” (Матай 2:13) үз.

Мэргэн Ухааны Үг хэмээн бидний мэдэх илчлэлтэд Их Эзэн ямар үг хэллэг хэрэглэснийг бодоод үз л дээ: “Хуйвалдагч хүмүүсийн зүрх сэтгэлд байгаа мөн эцсийн өдрүүдэд байх хилэнц хийгээд бодлуудын улмаас энэхүү мэргэн ухааны үгийг илчлэлтээр та нарт өгснөөр би та нарыг сэрэмжлүүлсэн билээ, мөн урьдаас сэрэмжлүүлж байна” (С ба Г 89:4).

Сүнслэг байдлаар урьдаас сэргийлэгдвэл сонор сэрэмжтэйгээр харж байх хэрэгтэй. Та бид “сэрэмжлүүлгийн өдөр” (С ба Г 63:58) амьдарч байгаа шүү дээ. Түүнчлэн бид сэрэмжлүүлэгдэж байсан мөн сэрэмжлүүлэгдэх болно, Төлөөлөгч Паулын зааснаар, бид “цөхрөлтгүй сэргэг байх” (Ефес 6:18) хэрэгтэй.

Сүнслэг байдлын хувьд эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоо нь хүүхдүүдийнхээ талаар анхаарал сэргэг байж, тэднийг ялган танихад Сион дахь эцэг эхчүүдэд тусалж чадна гэдгийг сануулахын хамт Ариун Сүнс намайг удирдахын төлөө би залбирч байна. Энэхүү сүнслэг байдлын хувьд эртнээс сэрэмжлүүлэх тогтолцоо нь бүх л насны хүүхдүүдэд хамаатай бөгөөд дараах гурван үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй юм: (1) хүүхдүүдтэйгээ хамт Мормоны номыг уншиж, уншсан зүйлээ ярилцаж байх, (2) сайн мэдээ үнэн болох талаар хүүхдүүдтэйгээ энгийнээр гэрчлэлээ хуваалцах, (3) сайн мэдээнээс суралцагчийн хувьд хүүхдүүд тань үйл хэргийг санаачлагч байхаас биш, бусад хүмүүс тэднээр үйлдүүлэхгүй байхыг нь хөхүүлэн дэмжих. Эдгээр зүйлсийг итгэлтэйгээр хийдэг эцэг эхчүүд хүүхдүүдэд нь ирэх сүнслэг байдлын өсөлтийн эсвэл тэдэнд тулгарах бэрхшээлийн урьдчилсан дохиог ялган харж, хүүхдүүддээ туслан, тэднийг бэхжүүлэх удирдамж хүлээн авахад илүү сайн бэлтгэгдэх болно.

Бүрэлдэхүүн хэсэг 1: Хүүхдүүдтэйгээ хамт Мормоны номыг уншиж, уншсан зүйлсээ ярилц

Мормоны Ном нь, Аврагчийн сайн мэдээг бүрнээр агуулсан бөгөөд Их Эзэний Өөрийнх нь үнэн хэмээн гэрчилсэн цорын ганц ном мөн (С ба Г 17:6; мөн Рассел М.Нелсон, “Мормоны Номын тухай гэрчлэл,” *Лиакона*, 2000 оны 1-р сар, 84-ийг үз). Мормоны Ном үнэхээр манай шашны тулгуурын чулуу мөн.

Мормоны Номын үнэмшүүлэн итгүүлэх, хөрвүүлэх хүч нь Их Эзэн Есүс Христэд төвлөрсөн хийгээд сургаалын тодорхой, ойлгомжтой байдлаас үүдэлтэй юм.

Нифай, “Тэд сурч болохын тулд, өөрийн хүмүүст тодорхойгоор ярихад бодгаль минь баяснам” (2 Нифай 25:4) хэмээн тунхаглажээ. Энэхүү шүлэг дэх “тод” хэмээх тодотгол үг нь энгийн, жирийн зүйлийг хэлж байгаа биш, харин ойлгомжтой, ойлгоход амархан гэсэн утгатай юм.

Мормоны Ном нь Үнэн дээр, бүр Есүс Христ дээр төвлөрдөг учраас, үнэн сайн мэдээнээс алга болсон (1 Нифай 13:26, 28-29, 32, 34-35, 40-ийг үз) энгийн болон эрхэм үнэт зүйлс дахин сэргээсэн учраас дэлхий дээрх номнуудаас хамгийн үнэн зөв нь юм (Иохан 14:6, 1 Нифай 13:40-ийг үз). Эдгээр хоёр хүчин зүйл - Аврагч дээр төвлөрдөг, сургаалыг тодорхой заадгийн өвөрмөц уялдаа холбоо нь Бурханы Тэргүүтний гурав дахь гишүүн Ариун Сүнсний батлах гэрчийг хүчтэйгээр урьдаг. Үүний үр дүнд, Мормоны Ном нь уншигчийн зүрх сэтгэл, сүнсэнд өөр ямар ч судартай зүйрлэшгүй нөлөөлдөг.

Мормоны Номон дахь заах захиасыг дагах нь ямар ч номноос илүүгээр “Бурханд илүү ойртоход” бидэнд туслах болно хэмээн Бошиглогч Иосеф Смит сургасан ажээ (*Teachings of Presidents of the Church: Joseph Smith* [2007], 64). Мормоны Номноос тогтмол уншиж, уншсан зүйлээ ярилцаж байх нь уруу таталтыг сөрөн зогсох хүчийг өгч, гэр бүл дотроо хайрыг илүү ихээр мэдрэхэд тусалдаг. Мормоны номон дахь сургаал болон зарчмуудын талаар ярилцах нь хүүхдүүдээ сонсож, тэднийг ажиглаж, тэднээс суралцаж мөн тэдэнд заах боломжийг эцэг эхчүүдэд олгодог. Бүх насны хүүхдүүд, бүр бага насны хүүхэд ч Мормоны Номын онцгой сүнсийг мэдэрдэг. Хүүхдүүд бүх түүх, бүх үгсийг ойлгохгүй байж болох ч Исаиагийн тайлбарласан тэрхүү “танил сүнсийг” (Исаиа 29:4; мөн 2 Нифай 26:16-г үз) мэдэрч чадна. Хүүхдийн асуух асуулт, тэдний ажигласан зүйлс, ярих үгс нь сүнслэг байдлын урьдаас сэрэмжлүүлэх дохиог мэдүүлдэг. Илүү чухал нь гэвэл, тиймэрхүү яриа хөөрөө энэхүү ариун номонд байдаг үнэнүүдийн талаар хүүхдүүд нь юу сурч, юу бодож байгаа, юуг мэдэрч байгаа талаар, түүнчлэн тэдэнд тулгарч болох бэрхшээлүүдийг мэдэхэд эцэг эхчүүдэд тусалдаг.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Гэрчлэлээ энгийнээр хуваалц

Мөнхийн ач холбогдолтой тодорхой мэдээллүүд үнэн хэмээн Ариун Сүнсний гэрчлэлийг хүлээн авсан хувийн мэдлэг бол гэрчлэл юм. Ариун Сүнс бол Эцэг, Хүү хоёрын элч, мөн бүх үнэний багш, удирдан дагуулагч мөн (Иохан 14:26, 16:23-ыг

үз). Тийнхүү, “Ариун Сүнсний хүчээр [бид] бүх зүйлийн үнэнийг мэдэж болно” (Моронай 10:5).

Ариун Сүнснээс бидний хүлээн авдаг мэдлэг, сүнсний сэнхрүүлэл нь илчлэлтийн үр дүн юм. Эдгээр адислалуудыг эрэлхийлж, олж авах нь Христэд итгэлтэй, чин үнэнч сэтгэлтэй, үнэн хүсэлтэй (Моронай 10:4) байхыг шаарддаг. Хувь хүний гэрчлэл хариуцлага, үүргийг бий болгодог.

Хүүхдүүдтэйгээ гэрчлэлээ хувцаалцах боломж гарах бүрд эцэг эхчүүд, ажигч гярхай, сүнслэг байдлын хувьд анхаарал соргог байх хэрэгтэй. Тиймэрхүү тохиолдол төлөвлөгдсөн, хуваарьтай эсвэл бичигдсэн байх хэрэггүй. Үнэндээ, тийм гэрчлэлээ хуваалцах нь төлөвлөгдөөгүй байх тусам сургах хүч, нөлөө нь шавхагдашгүй их байх болно. “Та нар юу хэлэхээ урьдаас бүү бод; харин амьдралын үгсийг оюундаа ямагт нөөцөл, мөн хүн болгонд хэмжигдэх тэрхүү хэсэг нь яг тэр цагт та нарт өгөгдөх болно”(С ба Г 84:85).

Жишээлбэл, оройн хоолны үеэр аяндаа үүсэх гэр бүлийн яриа хөөрөө нь эцэг эхийн хувьд тэр өдрийнхөө энгийн үйл ажиллагааны явцад хүлээн авсан тодорхой адислалаа хүүхдүүддээ хэлж, гэрчлэхэд хамгийн тохиромжтой үе байж болно. Мөн гэрчлэл нь, “Би та нартай гэрчлэлээ хуваалцъя” гэсэн үгсээр эхлэх нь алба биш. Бидний гэрчлэл энгийнээр, “Би өнөөдөр ажил дээрээ удирдамж авлаа” эсвэл “Энэ судар дахь үнэн миний хувьд байнга удирдамж чиглэлийн хүчит эх сурвалж болдог” гэх мэтээр яриагаа эхэлж болно. Гэрчлэлээ хуваалцах иймэрхүү боломж, машин дотор, автобусаар хамт явж байхад, эсвэл өөр олон янзын нөхцөлд тохиож болно. Иймэрхүү аяндаа гарч ирэх гэрчлэл хуваалцах тохиолдол хүүхдүүдийн оролцох хүсэл эсвэл эсэргүүцэл зэрэг хариу үйлдэл нь сүнслэг байдлын хувьд сэрэмжлүүлэх дохионы эх сурвалж байж болно. Гэр бүлээрээ судраас суралцахдаа олж мэдэж авсан сургамж эсвэл сайн мэдээний зарчим эсвэл дадал хэвшлийнтухай сэтгэл санааны зовнилынхоо талаар хүүхэд санал бодлоо хуваалцах нь дохиог өгч байгаа явдал мөн. Энэ нь бас уг хүүхдийнхээ асуулт, хэрэгцээг ойлгоход эцэг эхчүүдэд туслах болно. Тиймэрхүү яриа хөөрөө ялангуяа эцэг эхчүүд ярих хүсэлтэй байдаг шигээ бас сонсох хүсэлтэй байвал- гэр оронд аюулгүй байдал, бие биеэ дэмждэг орчныг бий болгож, бэрхшээл сорилтын талаар талаар илэн далангүй ярилцах уур амьсгалыг бий болгодог.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Хүүхдүүдийг үйлдэгч байхад урамшуулан дэмж

Бурханы бүтээлүүдийн агуу хуваарилалтаар, “үйлдэх зүйлүүд болон үйлдүүлэх зүйл” (2 Нифай 2:14) гэж байдаг. Тэнгэрлэг Эцэгийнхээ хүүхдүүдийн хувьд бид ёс суртахууны сонгох эрх болох бие даан үйлдэх хүч чадвараар адислагдсан юм. Сонгох эрх өгөгдсөнөөр бид сонгогчид бөгөөд гол нь үйлдэх,-ялангуяа бид “бүр судлахаар мөн тэрчлэн итгэлээр, суралцахыг эрэлхийлэхдээ” (С ба Г 88:118) үйлдэх ёстой, харин бусдаар үйлдүүлэх ёстой биш.

Сайн мэдээнээс суралцагчдын хувьд бид нар “зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид” байх ёстой (Иаков 1:22). Бид сонгох эрхээ зөвөөр ашиглаж, зөв зарчмуудын дагуу үйлдвэл Ариун Сүнсний нөлөө бидэнд ирж, бид Түүний заах, гэрчлэх хүч чадлыг урьдаг. Эцэг эхчүүд, хүүхдүүддээ санаачлагч байхад мөн итгэлээрээ сурахаар эрэлхийлэхэд нь туслах ариун үүрэг хариуцлага хүлээдэг. Ийм загвараар суралцахад хүүхэд хэзээ ч балчирдахгүй.

Хүнд загас өгвөл тэр ганц удаа л хоол хийж иднэ. Хүнд загас яаж барихыг зааж өгвөл тэр насан туршдаа идэх хоолтой болно. Эцэг эхчүүд болон сайн мэдээний багш нар бид загас тарааж өгөх ёстой хүмүүс биш; харин бидний хийх ажил бол хүүхдүүддээ “загас барьж” сурахад нь, сүнслэг байдлын хувьд бат бөх болоход нь туслах явдал юм. Бид хүүхдүүддээ зөв зарчмуудын дагуу санаачлагч байхыг урамшуулснаар - үйлдлээсээ сурахад тусалснаар – энэхүү амин чухал зорилго нь хамгийн сайнаар гүйцэлддэг. “Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсэж байвал, тэр нь энэ сургаал Бурханаас ирсэн үү гэдгийг мэднэ” (Иохан 7:17). Ингэж сурах нь зүгээр нэг хүлцэнгүй хүлээн авалтыг биш, сүнслэг байдлын, оюуны болон бие махбодын хүч чармайлтыг шаарддаг.

Хүүхдүүдээ сайн мэдээнээс суралцагчдын хувьд үйлдэж, харин үйлдүүлэхгүй байхад урамшуулах нь Мормоны Номыг уншиж, түүний талаар ярилцаж, гэр орондоо албадуулалгүйгээр аяндаа гэрчлэлээ хуваалцсанаас эхэлнэ. Жишээ нь, Мормоны Номноос уншиж, сурч мэдсэн зүйлийнхээ талаар – эсвэл сайн мэдээний талаарх ярилцлага юм уу гэр оронд бий болсон гэрчлэлээр гарч ирсэн сэдвийн талаар хүүхдүүд нь асуухыг урамшуулан дэмждэг гэр бүлийн үдшийг төсөөлөн бодоод үз л дээ. Эцэг эх нь бүрэн дүүрэн хариултыг өгч чадахааргүй асуултыг хүүхдүүд нь асууж байгааг нь төсөөлөн бодоод үз л дээ. Зарим эцэг эхчүүд, гэр бүлийн үдэш иймэрхүү зохион байгуулалтгүй байгаад санаа нь зовж байж болох юм. Гэхдээ хамгийн сайн гэр бүлийн үдэш гэхээр л, урьдчилан бэлтгэсэн, худалдан авсан, интэрнэтээс буулган авсан заавар, зурагтай байх албагүй л дээ. Гэр бүлийн

гишүүд хамтдаа судраас эрэлхийлж, судалснаар мөн итгэлээр суралцаж, Ариун Сүнсээр заагдах нь ямар агуу боломж билээ. “Учир нь номлогч нь сонсогчоосоо өчүүхэн ч илүү бус ажгуу, бас багш нь сурагчаасаа илүү бус бөлгөө; . . . мөн тэд бүгд, хүн бүр өөрт буй хүчнийхээ дагуу хөдөлмөрлөж байв” (Алма 1:26).

Та бид , ажиллаж, судалснаар мөн итгэлээр эрэлхийлдэг сонгогчид байхад нь хүүхдүүддээ тусалж байна уу, эсвэл бид хүүхдүүддээ бусад хүмүүс тэдэнд заахыг идэвхгүй хүлээж суудаг болгож байна уу, эсвэл өөрсдөө санаачлагч байхыг зааж өгч байна уу? Эцэг эхчүүд бид хүүхдүүдийнхээ сүнслэг байдлыг дээшлүүлэх гээд ихэвчлэн идэхэд бэлэн загасны адил зүйлийг өгч байна уу, эсвэл ажиллаж, өөрсдөө сурахад нь, тууштай, бат бөх байхад нь бид тэдэнд тогтмол тусалж чадаж байна уу? Гуйж, эрэлхийлж, тогшихдоо санаа сэтгэлээ бүрэн зориулж байхад бид хүүхдүүддээ тусалж байна уу? (3 Нифай 14:7-г үз).

Та бидний хүлээн авахаар адислагдсан сүнслэг ойлголт нь, бидний зүрх сэтгэлд үнэн хэмээн батлагдсан тэр зүйлийг хүүхдүүддээ зүгээр өгчихөж болдог зүйл биш. Судалснаар мөн итгэлээр суралцах нь шаргуу хичээнгүй байдлын төлөөс нь хувиараа тиймэрхүү мэдлэгийг “эзэмшсэнээр” төлөгдөх болно. Ийм л замаар оюун ухаанд ойлгогдох зүйл зүрх сэтгэлд мэдрэгдэх болно. Ийм л замаар хүүхэд, эцэг эх болон ахмад хүмүүсийн мэдлэг, туршлаган дээр тулгуурлахаа больж, өөрсдөө адислалуудыг эзэмшиж чадна. Ийм л замаар, хүүхдүүд маань эгэл амьдралд тулгарах сорилт бэрхшээлүүдэд сүнслэг байдлаар бэлтгэгдэж чадна.

Амлалт болон гэрчлэл

Хүүхдүүдтэйгээ Мормоны Номоос тогтмол уншиж, уншсан зүйлийнхээ талаар ярилцдаг, хүүхдүүдтэйгээ энгийнээр гэрчлэлээ хуваалцдаг, сайн мэдээнээс суралцагчийн хувьд хүүхдүүддээ үйлдэхэд, харин үйлдүүлэхгүй байхад урамшуулдаг эцэг эхчүүд холыг харах мэлмийгээр (Мосе 6:27), бүрээний дууг сонсох сонороор (Езекиел 33:2-16) адислагдах болно хэмээн би гэрчилж байна. Эдгээр гурван ариун зуршлаас та нарын хүлээн авах сүнслэг удирдамж, ялган таних чадвар нь гэр бүлийнхээ төлөө цамхаг дээр харуул болон зогсож – “цөхрөлтгүй сэргэг байж” (Ефес 6:18) – гэр бүл болон үр удмаа адислах боломжийг та бүхэнд олгоно. Би ийн амлаж, мөн Их Эзэн Есүс Христийн ариун нэрээр гэрчилж байна, амен.